



Үндсэн багцын шинжилгээний бэлтгэл

Шээсний шинжилгээний бэлтгэл:

- Гадна бэлэг эрхтэнг угааж арчисны дараа ариутгасан зориулалтын савны тагийг зөвхөн шээх үедээ онгойлгож шээсний дунд хэсгээс өгнө.
- Шөнийн турш давсганд хуримтлагдсан өглөөний шээснээс зориулалтын ариун саванд авч 2 цагийн дотор лабораторит хүргэсэн байна.
- Хэрвээ 2 цагаас илүү хугацаагаар хадгалсан бол устгаж, эхний шээснээс хойш 2 цаг орчим давсганд хуримтлагдсан шээсний дунд хэсгээс дахин зориулалтын саванд авч өгнө.
- Шээсний ерөнхий шинжилгээний сорьцыг хөлдөөж болохгүй.

Цусны шинжилгээний бэлтгэл:

- Өлөн байх /8–12 цагийн турш хоол идээгүй болон газтай болон чихэрлэг ундаа, зөгийн бал болон чихэртэй цай уугаагүй байх/
- 24 цагийн өмнөөс архи согтууруулах ундаа хэрэглээгүй, өөх тос ихтэй хоол идээгүй байх, биеийн хүчний дасгал болон хэт ачаалал аваагүй байвал илүү тохиромжтой.
- Цусны шинжилгээ өгөхөөс өмнө 15 минут орчим тайван суух хэрэгтэй.
- Цус өгөхийн өмнө эхо, дуран, рентген зэрэг багажийн шинжилгээнд ороогүй, судсаар тодосгогч бодис хэрэглээгүй байна.

Зүрхний бичлэг хийлгэхээс өмнө шатаар дээш доош хурдан алхаагүй, гүйгээгүй байх ба хэрвээ ямар нэгэн ачаалал авсан бол 5–10 минут орчим тайван сууна.

Хэвлийн эхо: Өлөн байх

Цээжний рентген зураг:

- Хэрвээ та жирэмсэн бол рентген шинжилгээ хийлгэхээс зайлсхийх хэрэгтэй.
- Шаардлагатай тохиолдолд сувилагчид хэлж хамгаалалтын хормогч зүүх хэрэгтэй.

Баасны шинжилгээний бэлтгэл:

Хеликобактерийн шинжилгээг цус, баас, амьсгал болон ходоод дурандах явцад эд авах зэргээр шинжилдэг. Баас, эдийн шинжилгээ болон амьсгалын сорилоор хеликобактерийн идэвхтэй халдварыг тодорхойлох ба идэвхтэй үед эмчилгээ хийх шууд заалт болдог. Шинжилгээг өгөхдөө ус болон шээстэй холилдоогүй баасны хэсгийг цаас болон жорлонгийн суултуурт наалдуулж авна. Зориулалтын савны таганд урт савх байх ба баасны энд тэндээс /3–4 хэсэг газраас/ уг савхаараа дүрж, наалдуулж аваад тагийг шууд таглана. Няан судлалын лабораторид /B1/ хүргэж өгнө.

Тухайн өдрөө шинжилгээгээ өгөх боломжгүй бол зориулалтын савыг авч яваад зааврын дагуу авч хөргөгчний хажуу хаалганд хадгалж (–4 –8 градуст) байгаад авчирч өгнө.

Жич: Дээрх шинжилгээний хариу гарсны дараа нэмэлт шинжилгээ шаардлагатай бол төлбөр тусдаа тооцогдоно.

Бусад нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлага гарвал 7 хоног дотор үзлэгийн төлбөрөөс 50%–ийн хөнгөлөлт эдлүүлнэ.